



УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 2/02

Улаангом

Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны дүрэм, журмуудыг батлах тухай

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны дүрэм, журмуудыг хэлэлцээд Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь зүйл, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байнгын дэгийг 1-р, ИТХ-д асуудал өргөн мэдүүлэх, хуралдааны бэлтгэл хангах журмыг 2-р, Төлөөлөгчийн ажиллах журмыг 3-р, Тэргүүлэгчийн ажиллах журмыг 4-р, Хурлын хорооны ажиллах журам, нэр, эрхлэх асуудал, бүрэлдэхүүнийг 5-р, Намын бүлгийн ажиллах журмыг 6-р, Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн хяналт, хоригийг шийдвэрлэх журмыг 7-р, ИТХ-аас аймгийн Засаг дарга, ЗДТГ, бусад байгууллага, иргэдтэй харилцах, хамтран ажиллах журмыг 8-р, төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг 9-р хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр.Дээрх дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөхийг аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнд нь хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байхыг аймгийн ИТХ-ын дарга, тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ажлын албанд үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү журмуудыг жишиг болгон өөрийн дотоод зохион байгуулалтын асуудлаа тусгасан журмуудыг боловсруулан баталж мөрдөхийг сумдын ИТХ-ын дарга нарт даалгасугай.

Дөрөв. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын 2013 оны 12-р сарын 02-ны өдрийн хуралдааны 5/04, 5/05 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Э.НАСАНБАТ